



«Альтернатива» хуванцар эдлэлийн үйлдвэр (ХЭҮ) ХХК

«Альтернатива» хуванцар эдлэлийн үйлдвэр нь 1988 оноос өөрийн түүхийг эхлүүлсэн. Энэ үйлдвэр нь Орос, ТУХН-ийн орнууд ба Европт ахуйн зориулалттай хуванцар эдлэлийг гаргадаг өндөр технологийн томоохон үйлдвэрүүдийн нэг юм.



«Альтернатива» үйлдвэр нь зөвхөн хамгийн сайныг санал болгодог. Үүнд бүтээгдэхүүний чанар, үйлчилгээний түвшин ба төрөл зүйл нь хамаарна. Бүтээгдэхүүний чанарыг сайжруулах болог төрөл зүйлийг өргөтгөхөд олон бүрэлдэхүүнт цутгах технологи болон бүтээгдэхүүн дээр зураг зурах хэд хэдэн технологийг хэрэглэх болсон нөлөө үзүүлсэн. Үйлдвэрлэх явцад бүх бүтээгдэхүүн нь байнгын хяналт доор байдаг. Энэ салбарынхаа ижил төстэй үйлдвэрүүдийн дунд тэргүүлэх байр эзлэх боломжийг олгодог.

Жил бүр үйлдвэр нь өөрийн төрөл зүйлд 350 хүртэл шинэ бүтээгдэхүүн нэмдэг. Өнөөдрийн байдлаар, «Альтернатива» үйлдвэр нь өөрийн худалдан авагчдад барааны янз бүрийн бүлэгт хамаарах, хэрэглэгчдийн аливаа шаардлагыг хангах 3000 гаруун нэр төрлийн бүтээгдэхүүнийг санал болгож байна:

- гэр ахуйн бараа бүтээгдэхүүнүүд (мебель, гал тогооны хэрэгслүүд, цэцгийн сав, хэрэгслүүд, угаалгын өрөө болон ариун цэврийн өрөөний хэрэгслүүд, гэрийн амьтдад зориулсан хэрэгслүүд, хувин, сав суулга гэх мэт);
- хүүхдэд зориулсан бараа бүтээгдэхүүнүүд (мебель, тоглоомын цуглуулгууд, сав, хайрцаг гэх мэт);
- ногооны талбай, цэцэрлэгийн бараа бүтээгдэхүүнүүд (канистр, усны сав, торх, цэцэрлэгийн тор, шүршигч, усалгааны сав, суулгац, цэцгийн бүтээгдэхүүн, хашаа гэх мэт);
- бэлгийн цуглуулга.



Компаний чанарын удирдлагын систем нь олон улсын ISO 9001:2015 стандартын шаардлагуудад нийцдэг.

«Альтернатива» хуванцар эдлэлийн үйлдвэр ХХК ISO 22000:2018, ISO 45001:2018, ISO 14001:2015 стандартуудын шаардлагуудыг үйлдвэрлэлдээ нэгтгэн хэрэглэдэг.

Бүх бүтээгдэхүүн нь гэрчилгээжсэн ба дотоодын болон гадаадын үйлдвэрлэлийн байгальд ээлтэй чанартай, цэвэр материалуудаар хийгддэг. Үйлдвэрт хийсэн бүтээгдэхүүнүүд орчин үеийн загвартай, өнгө тод, өргөн сонголт болон үнийн хувьд хямд байдаг учраас худалдан авагчдын хувьд сонирхлыг татдаг. Олон загварууд нь патенттай. Многие модели имеют патент. «Альтернатива» үйлдвэр 120 бүтээгдэхүүнийг «Уолт Дисней» компаний лицензийн гэрээний дагуу үйлдвэрлэдэг.

Үйлдвэрийн нийлүүлэлтийн газар зүй нь өргөн цар хүрээтэй. Обширна и география поставок завода. Хүнд даацын автомашины парк, бэлэн бүтээгдэхүүнийг хадгалах, хэрэглэгчдэд хүргэх агуулах бүхий өөрийн диспетчер-ложистикийн төвтэй. Томоохон тээврийн компаниуд үйлдвэртэй хамтран ажилладаг. Хол болон ойрын гадаад улсуудтай хийх импорт, экспортын үйл ажиллагааг тогтворжуулсан. Бүтээгдэхүүнийг сайжруулах, борлуулахад бүх нөөц боломжийг дайчилж байгааг компанийн вэбсайт руу ороход харж болно - вэбсайтад онлайн дэлгүүр идэвхтэй ажиллаж байгаа.



«Альтернатива» ХЭҮ ХХК нь Москва ба гадаадад зохиогддог оросын болон олон улсын хэмжээний төрөлжсөн үзэсгэлэнгийн байнгын оролцогч бөгөөд Бүгд найрамдах улсын "Башкортостаны шилдэг бараа"-ны уралдаан, Бүх Оросын "Оросын 100 шилдэг бараа"-ны уралдаан зэрэг төрөл бүрийн уралдаануудад оролцдог. Олон тооны диплом, шагналууд нь байгууллагын өндөр мэргэжлийн ур чадвар, нэр хүндийг улам баталгаажуулдаг.



